



# ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ /ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ/

2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Баян-Өндөр сум

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	Стратеги төлөвлөгөөний зорилт-1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох зорилт бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх	Улсын төсөв – 13.0 сая төгрөг	Иргэдийн бие бялдрын хөгжлийн түвшин дээшилж, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөл сайжирч биеийн тамирын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байх	Биеийн тамир, өдөрлөгийн арга хэмжээ 130, сорилд хүн амын 46.8%, спорт заал 33	Биеийн тамир, өдөрлөгийн арга хэмжээ 155, сорилд хүн амын 9.4% буюу 12000 хүнийг хамруулж 54% нь А, В,С үнэлгээ, чөлөөт цагийн 66 талбайн ашиглалт сайжирсан байна.	Биеийн тамирын өдөрлөгийн арга хэмжээ 160, сорилд хүн амын 9.4 % буюу 11219 хүнийг хамруулж 84.1% нь А, В, С үнэлгээтэй, чөлөөт цагийн 117 талбайн ашиглалтад тооллого хийж ажилласан.	92.5%
1.1	<b>Арга хэмжээ-1:</b> Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд аван, дүн мэдээг программд нэгтгэн оруулж Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын хэлтэст тайлагнана.	Улсын төсөв 10.0 сая төгрөг	Сорилд хамрагдсан хүн амын эзлэх хувь ба тэдгээрээс А, В, С-гийн эзлэх хувь	Суурь үзүүлэлт 2019 онд хүн амын 9.4% сорилд хамруулж А, В, С үнэлгээтэй иргэдийн хувь 46.8	А, В, С үнэлгээтэй иргэдийн тоог 2022 онд 54 хувьд хүргэнэ.	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар “Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд сорил авах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 01-нээс 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрүүдэд зохион байгуулж, Сорилд хүн амын 9.4 хувь буюу 11219 иргэдийг хамруулснаас 84.1% нь А, В, С үнэлгээтэй байна.Үүнээс: -А үнэлгээтэй – 2796 хүн -В үнэлгээтэй – 3420 хүн -С үнэлгээтэй – 3215 хүн	100%

						-Д үнэлгээтэй – 1145 хүн -F үнэлгээтэй – 643 хүн байна.	
1.2	<b>Арга хэмжээ-2:</b> Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах	-	Гэрээ байгуулсан спорт холбоодын тоо	63 спорт холбоо, 11 спортын клуб	2022 онд аймгийн өсвөрийн шигшээ баг хариуцсан спортын төрлүүд болох 10 спорт холбоотой гэрээ байгуулж хамтран ажилласан байна.	Орхон аймагт Улсын бүртгэлд спортын чиглэлээр Төрийн бус спорт холбоо 63, спортын клуб 11 бүртгэлтэй байгаагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 26 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан. Үүнд: буудлага, сагсан бөмбөг, даам, шатар, пауэрлифтинг, волейбол, цана, хөл бөмбөг, 2 унадаг дугуйн холбоо, жүдо, чөлөөт бөх, самбо бөх, таеквондо, ширээний теннис, хүндийн өргөлт, хоккей, спортын бүжиг, гимнастик, үндэсний бөх, мөсний шагайн “Мөнгөн толь”, шагайн харвааны “Цэц мэргэн”, үндэсний сурын холбоо, суугаа волейболын “Бид чадна” холбоо, Монголын хараагүйчүүдийн холбоо, Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Орхон аймгийн салбар зөвлөл.	100%
1.3	<b>Арга хэмжээ-3:</b> Биеийн тамирын арга зүйчдийг мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Улсын төсөв 3.0 сая төгрөг	Сургалтад хамруулсан арга зүйчийн тоо	-	2022 онд 2 арга зүйчийг сургалтад хамруулна.	Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааны хүрээнд зохион байгуулагдсан “Хүүхдийн спорт өнөө ба ирээдүй” сэдэвт олон улсын XII форумд 1 мэргэжилтэн, “Допингийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах нь” сургалтад 1 мэргэжилтэн, 1 биеийн тамирын багш тус тус хамрагдсан.	100%
1.4	<b>Арга хэмжээ-4:</b> Орон сууцны болон гэр хорооллын дундах спорт, чөлөөт цагийн талбайн ашиглалтыг сайжруулах талаар холбогдох	-	Ашиглалтыг сайжруулсан талбайн тоо	Сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөгийн талбай-117	Спорт, чөлөөт цагийн 66 талбайн ашиглалтыг сайжруулна.	Тус газрын даргын баталсан хуваарийн дагуу аймгийн хэмжээнд орон сууцны болон гэр хорооллын амралт, чөлөөт цагийн талбайн ашиглалтад тооллого, судалгаа хийж ажилласан.	70%

	байгууллагуудтай хамтран ажиллана.				<p>Баян-Өндөр сумын 22 баг, Жаргалант сумын 1 багт амралт, чөлөөт цагийн талбайд иргэд, хүүхэд багачууд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлж спортоор хичээллэж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Зэст багт – 5</li> <li>2.Уртбулаг багт – 5</li> <li>3.Бүрэнбүст багт – 5</li> <li>4.Оюут багт – 12</li> <li>5.Баянбулаг багт – 4</li> <li>6.Булаг багт – 4</li> <li>7.Цагаанчулуут багт-8</li> <li>8.Рашаант багт -3</li> <li>9.Даваат багт – 5</li> <li>10.Наран багт -7</li> <li>11.Шанд багт -2</li> <li>12.Баянцагаан багт – 3</li> <li>13.Их залуу багт-4</li> <li>14.Яргуйт багт – 3</li> <li>15.Зэст багт -6</li> <li>16.Уурхайчин багт -4</li> <li>17.Дэнж багт – 7</li> <li>18.Говил багт-5</li> <li>19.Уртын гол багт – 4</li> <li>20.Эрдэнэ багт -5</li> <li>21.Хүрэнбулаг баг -6</li> <li>22.Согоот багт -4</li> <li>23.Жаргалант суманд -3 нийт 117 байршилд сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөгийн талбай болон чөлөөт цагийн талбай ашиглагдаж байна. Биеийн тамир, спортын газраас амралт чөлөөт цагийн 8 талбайд 500 гаруй иргэдийг дасгал хөдөлгөөнд, спортын 2 удаагийн тэмцээнд 560 гаруй тамирчдыг хамруулж ажиллалаа. чөлөөт цагийн талбайн тохижилт, ашиглалтыг сайжруулах тал дээр Хотын захирагчийн алба, багуудын ажлын алба болон Хот</li> </ol>	
--	------------------------------------	--	--	--	---	--

						тохижуулах газар, СӨХ-үүдтэй хамтран ажиллаж байна.	
	Стратеги төлөвлөгөөний зорилт-2. Биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй нэг хэсэг болгож, идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжих, мэргэжлийн спорт баг тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсөв – 20.0 сая төгрөг	Иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлж, хэвшүүлэн нийтийн дасгал хөдөлгөөнийг иргэдийн дунд өрнүүлсэн байна.	Зохион байгуулсан тэмцээн-7, тогтмол үйл ажиллагаа явуулсан спортын фитнес клуб-11	Сспортын 10 төрлөөр 13 удаа тэмцээн зохион байгуулна. Спортын 11 фитнес клуб тогтмол үйл ажиллагаа явуулна.	Төрийн болон төрийн бус 44 байгууллагуудтай хамтран ажиллаж биеийн тамир чийрэгжүүлэлтийн 160 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 62612 иргэнийг хамруулсан. Үүнээс: ахмад настны тэмцээн уралдаан 12, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг, тэмцээн уралдаан 12, бүх нийтийн гүйлт 3, өглөөний дасгалд 127, бусад арга хэмжээ 5 тус тус зохион байгуулж ажилласан.	93.1%
2.1	<b>Арга хэмжээ-1:</b> Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубийн тоог нэмэгдүүлэх	-	Спортын магадлан итгэмжлэлд хамрагдсан клубийн тоо	Спортын магадлан итгэмжлэл авсан 3 фитнес клуб	1 фитнес клуб шинээр спортын магадлан итгэмжлэлд хамрагдсан байна.	Манай аймгийн хэмжээнд 13 фитнес клуб үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3 клубүүд магадлан итгэмжлэл авч ажиллаж байна. Тайлант онд 1 клуб спортын магадлан итгэмжлэлд хамрагдахаар материалаа ирүүлснийг Засгийн Газрын Тохируулагч Агентлаг-Биеийн Тамир, Спортын Улсын Хороонд албан бичгээр хүргүүлсэн. Тайлант онд фитнес клубээр хичээллэгсдийн тоог 130-аар нэмэгдүүлж, 1750 иргэн тогтмол хичээллэж байна.	50%
2.2	<b>Арга хэмжээ-2:</b> Шинээр хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв 2.0 сая төгрөг	Зохион байгуулсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо	Софт волейбол, граунд гольфийн спортоор 80 гаруй тамирчин хичээллэж аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2	2022 онд хичээллэгчдийн тоог 130-д хүргэж тэмцээн уралдааныг 3 удаа зохион байгуулсан байна.	Аймгийн хэмжээнд шинээр софт волейбол, граунд гольф, бочи спортын төрлүүдийг хөгжүүлэн тамирчдыг дэмжин 6 удаагийн тэмцээн зохион байгуулж 287 тамирчдыг хамруулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>софт волейболын спортоор 4 удаа тэмцээн зохион байгуулж 3 насны ангилалд 240 тамирчин;</li> </ul>	100%

				удаа зохион байгуулсан.		<ul style="list-style-type: none"> <li>• граунд гольфийн тэмцээнд 32 тамирчин;</li> <li>• хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохиогдсон бочигийн тэмцээнд 15 тамирчин;</li> </ul> <p>Граунд гольфийн спортоор 130 тамирчин тогтмол хичээллэж байна. Мөн агаарын шүхэр, техник спортыг хөгжүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p>	
2.3	<p><b>Арга хэмжээ-3:</b> Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжих</p>	Аж ахуйн нэгж байгууллагуудын зардлаар	Түрээсийн үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, байгууллага-2	Түрээсийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 3 болсон байна.	<p>Тайлант онд 4 байршилд 3 иргэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, уулын цана, чарга, тэшүүр, ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг 6700 гаруй хүүхэд залууст хүргэж ажиллалаа.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Эрдэнэт спорт амралтын хүрээлэнг”-ийн 400 метрийн мөсөн талбайд тэшүүрийн түрээсийн үйлчилгээнд 1200 гаруй хүүхэд залуус,</li> <li>2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Сархиа цанын баазад чарга, уулын цана, тэшүүр, хоккейн спортоор 2000,</li> <li>3. А.Амарын талбай, “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д ердийн болон гэр бүлийн дугуйн төлбөрт үйлчилгээг үзүүлж давхардсан тоогоор 3500 иргэн тус тус хамрагдсан.</li> </ol>	100%
2.4	<p><b>Арга хэмжээ-4:</b> Ахмад настанд спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж</p>	Орон нутгийн	Хамрагдсан иргэдийн тоо	2021 онд софт волейболын тэмцээнд 60	Биеийн тамир, спортын арга хэмжээг спортын 5	Тайлант онд ахмадуудын дунд спортын 9 /софт волейбол, дартс, явган алхалт, волейбол, сагсан бөмбөг, буухиа, хөл бөмбөг, гүйлт/	100%

	хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх	төсөв 5.0 сая төгрөг		ахмад настан хамрагдсан.	төрлөөр 8 удаа зохион байгуулж 800 иргэн хамрагдсан байна.	төрлөөр 12 удаагийн арга хэмжээг аймгийн Ахмадын хороо, Монголын ахмад мастеруудын хорооны Орхон аймгийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж нийт 850 ахмад настаныг хамруулсан. Мөн БТСГ-ын А, Б заал, Баян-Өндөр сумын спорт заал, аймгийн ЗДТГ-ын спорт заал, нийт 4 спорт зааланд үнэ төлбөргүй 7 хоногт 2 цагаар 5 өдөр софт волейбол, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөгийн спортоор хичээллэж чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлж давхардсан тоогоор 610 ахмад хичээллэж байна.	
2.5	<b>Арга хэмжээ-5:</b> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулах тэмцээний төрлийг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг	Тэмцээний төрөл, хамруулсан иргэдийн тоо	2021 онд спортын 3 төрлөөр 3 удаа тэмцээн зохион байгуулж 112 иргэн хамруулсан	Биеийн тамир, спортын арга хэмжээг 5 төрлөөр 5 удаа тэмцээн зохион байгуулж 300 иргэнийг хамруулна.	2022 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 9 /пара хөнгөн атлетик, 3x3 сагсан бөмбөг, буухиа, дартс, ширээний дуут бөмбөг, волейбол, хонхот бөмбөг,суугаа волейбол, бочи / төрлөөр 12 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 509 иргэдийг хамруулсан.	100%
2.6	<b>Арга хэмжээ-6:</b> Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж “Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх	Орон нутгийн төсөв 3.0 сая төгрөг	Дасгал хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо	2021 онд-давхардсан тоогоор 9500 хүн хамрагдсан.	“Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье” аяныг аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлж давхардсан тоогоор 9600 иргэн бүх нийтийн дасгал	“Хичээллэе-Хэвшүүлье-Өрнүүлье” аян болон Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар 02 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдөр хүртэл зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны арга хэмжээг аймгийн хэмжээнд өглөө бүр 06.30-07.30 цагт зохион байгуулж ажиллалаа. Аяны хүрээнд аймгийн хэмжээнд спорт заал 4, гадна талбай 9, танхим 11, бүжгийн клуб 1, төрийн болон төрийн бус 44 байгууллага, иргэд хамтран ажиллаж нийт давхардсан тоогоор аймгийн 44856	100%

					хөдөлгөөнөөр хичээллэж хэвшсэн байна.	иргэн аянд нэгдэж идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэж, эрүүл амьдралын дадлыг хэвшүүлсэн. Аймгийн Хангарьд спорт клуб, Ахмадын хороо, Эрдэнэт сувилал, Эрүүл мэндийн газар, 8 өрхийн эрүүл мэндийн төвд нийт 120 иргэн хийн дасгалаар тогтмол хичээллэж байна. Мөн аймгийн Гимнастикийн холбоотой хамтран "Гимнастрада-2022" өдөрлөгийг 05 дугаар сарын 29-ний өдөр А.Амарын талбайд амжилттай зохион байгуулсан. Өдөрлөгт ерөнхий боловсролын сургууль, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, ахмад настан, спорт клубийн нийт 15 байгууллагын 2000 иргэн Японы Радиоогийн "Тайсо" дасгалыг хийж гүйцэтгэсэн. Биеийн тамир, спортын газраас өглөөний дасгалд хамрагдах ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд зориулж аймгийн гимнастикийн холбоо, соёл урлагийн төрөлжсөн сургалттай "Уран эгшиг" сургууль, орон нутгийн EBS телевизтэй хамтран "148 тоот брэнд дасгал"-ыг зохион видео хэлбэрээр бичлэг хийлгэсэн. "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудад "Нэг анги-нэг өглөө" арга хэмжээг зохион байгуулж байна.	
2.7.	<b>Арга хэмжээ-7:</b> "Авто машингүй нэг өдөр" арга хэмжээ зохион байгуулна.	Орон нутгийн төсөв 1.0 сая төгрөг	Хамрагдсан иргэдийн тоо	2021 онд 260 иргэнийг хамруулсан.	300 иргэнийг биеийн тамир спортын арга хэмжээнд хамруулна.	2022 онд "Авто машингүй нэг өдөр" арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, 5 удаагийн уралдаан тэмцээнд 1837 иргэнийг хамруулсан.Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн баярын өдөр буюу 2022 оны 06 дугаар сарын 01-ний</li> </ul>	100%



						<p>өдрөөр “Автомашингүй нэг өдөр”-ийн арга хэмжээг Монгол Улсын Ерөнхий сайд асан А.Амарын нэрэмжит төв талбайд спортын 5 төрлөөр /сагсан бөмбөг 65, гимнастикийн 20, хөлбөмбөгийн 12, таеквандо 25, жүдо бөхийн 18/ нийт 140 хүүхдийн үзүүлэх тоглолт, 6-11 насны хүүхдийн дунд унадаг дугуй, 12-13 нас буухиа тэмцээн, 10-14 нас Олимпизмын боловсрол олгох “Аха” тэмцээн, 14-16 насны хүүхдийн дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг 3 насны ангиллаар зохион байгуулж нийт 194 багийн 1072 хүүхдийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр “Автомашингүй нэг өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд “Эрдэнэт марафон-2022” бүх нийтийн кросс гүйлтийн тэмцээнийг Монгол Улсын Ерөнхий сайд асан А.Амарын нэрэмжит төв талбайд 12-13, 14-15, 16-18, 19-25, 26-39, 40-49, 50-иас дээш нийт 7 насны ангиллаар зохион байгуулж тэмцээнд 700 гаруй иргэдийг хамруулсан.</li> <li>• “Шри Чинмойн Эрдэнэт марафон” бүх нийтийн кросс гүйлтийн тэмцээнийг 2022 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр А.Амарын нэрэмжит төв талбайд зохион байгуулсан. Бүх нийтийн кросс гүйлтийг 10-17 нас, 18-34 нас, 34-</li> </ul>
--	--	--	--	--	--	---

						49 нас, 50-иас дээш 4 насны ангилалд нийт 65 иргэн оролцсон.	
2.8	<b>Арга хэмжээ - 8:</b> Аймгийн хэмжээнд Иргэдийн наадмыг байгуулах спортын зохион	Орон нутгийн төсөв 7.0 сая төгрөг	Зохион байгуулсан спортын төрлийн тоо, хамрагдсан иргэдийн тоо	Иргэдийн спортын наадамд 859 иргэн хамрагдсан.	Баян-Өндөр, Жаргалант сумын 24 багийн иргэдийн дунд спортын 5 төрлөөр зохион байгуулж 950 иргэн хамруулна.	Иргэдийн спортын наадмын буудлагын тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр БТСГ-ын Уурхайчин заалны хийн буудлагын тринд зохиогдож, 17 багийн 68 тамирчин, үндэсний бөхийн тэмцээн 2022 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр БТСГ-ын Уурхайчин зааланд зохиогдож 15 багийн 37 бөх, ширээний теннисийн тэмцээн 2022 оны 12 дугаар сарын 03-наас 04-ний өдрүүдэд зохиогдож 16 багийн 64 тамирчин, волейболын тэмцээнд 2022 оны 12 дугаар сарын 03-наас 04-ний өдрүүдэд зохиогдож 19 багийн 304 тамирчин, олс таталтын тэмцээн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр БТСГ-ын А заал, Уурхайчин заал, аймаг, сумын ЗДТГ-ын спорт зааланд зохиогдож 18 багийн 144 тамирчин оролцлоо. Сагсан бөмбөгийн тэмцээн 2022 оны 12 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд БТСГ-ын А заал, Уурхайчин заал, аймгийн ЗДТГ-ын спорт зааланд зохиогдох бөгөөд 20 багийн 280 тамирчин оролцоно.	94.4%
	Стратеги төлөвлөгөөний зорилт-3: Монгол үндэсний уламжлалт спортыг орон нутагтаа хөгжүүлэх, сурталчлах, зохион байгуулах	Орон нутгийн төсөв 14.0 сая төгрөг	Үндэсний спортын төрлийн тоо, хамрагдсан иргэдийн тоо	Үндэсний спортын 5 холбоотой хамтран 5 удаа тэмцээн зохион байгуулсан.	Үндэсний спортын 6 холбоотой хамтран 6 спортын 6 төрлөөр арга хэмжээ зохион явуулж 2000 иргэнийг хамруулах	Үндэсний спортын 5 холбоотой хамтран спортын 9 төрлөөр 46 удаагийн тэмцээн уралдаан зохион явуулж 3706 тамирчдыг хамруулж ажилласан.	100%

3.1	<p><b>Арга хэмжээ-1:</b> Монгол уламжлалт дэмжин үндэсний спортын төрлүүдээр аварга болон тэмцээн тогтмол зохион байгуулах үндэсний спортыг хөгжүүлж аймгийн нэрэмжит зохион байгуулах</p>	Орон нутгийн төсөв 10.0 сая төгрөг	Нэмэгдсэн үндэсний спортын төрлийн тоо, хамрагдсан иргэдийн тоо	Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнийг спортын 5 төрлөөр зохион байгуулж 1900 иргэн хамруулсан.	2022 онд үндэсний спортын 6 төрлөөр, тэмцээн уралдааныг нас, насны ангиллаар зохион байгуулж орон нутгийн 2000 иргэнийг хамруулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.	<p>Үндэсний спортын /шагай, ширээний шагай, мөсний шагай, сур харваа, мөсний сур харваа, үндэсний бөх, эмнэг булгиулагч, уран уургач, жороо морь/ 9 төрлөөр аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит, үндэсний спортын VII дугаар наадмын шигшээ тэмцээнүүдэд нийт 3706 тамирчдыг хамруулж, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллалаа.</p> <p>Зохион байгуулсан тэмцээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг үндэсний спортын 9 төрлөөр зохион байгуулж 570 тамирчин,</li> <li>• Нэрэмжит тэмцээнийг спортын 3 төрлөөр /мөсний шагай, шагайн харваа, үндэсний сур/ 11 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 846 тамирчин;</li> <li>• Үндэсний бөхийн барилдааныг өсвөр үеийнхний дунд 13 удаа зохион явуулж 1062 тамирчин, насанд хүрэгчдийн дунд 9 удаа зохион байгуулж 704 бөх нийт 1766 тамирчин;</li> <li>• Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны 2022 оны гэрээний хүрээнд “Хангинахуйн шугуйн шагайн тойром” соёл, спортын арга хэмжээг Булган аймгийн Хутаг-Өндөр суманд хамтран зохион байгуулж, арга хэмжээний үеэр хүчит бөхийн барилдаанд 128 бөх, шагайн харвааны тэмцээнд нийт</li> </ul>	100%
-----	--	------------------------------------	---	---	---	---	------

						44 багийн 396 харваач тус тус оролцсон.	
3.2	<b>Арга хэмжээ-2:</b> Үндэсний уламжлалт спортын холбоодод дэмжлэг үзүүлэн аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээн зохион явуулах	Орон нутгийн төсөв 4.0 сая төгрөг	Зохион байгуулсан тэмцээний тоо	Үндэсний спортын 5 холбоотой хамтран ажиллаж байна.	Үндэсний спортын холбоотой хамтран ажиллаж тэмцээн зохион байгуулсан байна.	Тайлант онд үндэсний бөхийн холбоо, мөсний шагайн “Мөнгөн толь”, шагайн харвааны “Цэц мэргэн” холбоо, үндэсний сурын холбоо, Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн Орхон аймгийн салбар хороотой хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 41 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж 3182 тамирчдыг хамруулсан.	100%
	Стратеги төлөвлөгөөний зорилт-4: Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааны шаталсан тогтолцоо зэрэглэлийг бий болгож, төр төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын бүс, улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна.	Улсын төсөв – 15.0 сая төгрөг, Орон нутгийн төсөв – 255.0 сая төгрөг	Сургалт дасгалжуулалтын чанарт ахиц гарч төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, тамирчдын ур чадвар амжилт нэмэгдсэн байх	Аймгийн хэмжээнд 63 салбар холбоод, бүс, улс, олон улсын медаль-370 тамирчин, дасгалжуулагч- 35 байна.	Спортын тэмцээн уралдааныг амжилттай зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо нэмэгдүүлж тамирчдын амжилт ахисан байна.	Аймгийн хэмжээнд спортын 35 төрлөөр 415 удаагийн тэмцээн, уралдаанд давхардсан тоогоор 56000 иргэн, 47 төрлийн секц, дугуйланд 24500 гаруй хүүхэд, залуучууд, иргэдийг хамруулж, тив дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 456 медаль авсан амжилтыг үзүүлсэн.	98.4%
4.1	<b>Арга хэмжээ-1:</b> Аймгийн өсвөрийн шигшээ багийн залгамж халааг сайжруулах улс, бүс, олон улсын түвшинд өрсөлдөх Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоог нэмэгдүүлж, хэрэглэл материалаар хангах	Орон нутгийн төсөв 50.0 сая төгрөг	Спортын төрлийн тоо, хамрагдсан тамирчдын тоо	2021 онд Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ баг нь спортын 15 төрөлд 154 тамирчин	2022 онд спортын 16 төрлөөр 168 тамирчнаар нэмэгдүүлнэ.	2022 онд өсвөрийн шигшээ багт теннисний төрлийг шинээр нэмж, тамирчдын тоог 14-өөр нэмэгдүүлж, нийт 15 төрөлд 168 өсвөрийн тамирчин бэлтгэл сургуулилалт хийж байна.  Өсвөрийн шигшээ багийн төрөл, тамирчдын тоо: сагсан бөмбөг 3х3, 5х5 төрөлд 28 хүүхэд, байт харваа-8, гимнастик-8, цана-8, хөлбөмбөг-20, бадминтон-8, бокс-8, буудлага-8, таеквондо-8, ширээний теннис-6, самбо, жүдо-16, чөлөөт бөх-10,	100%

						<p>волейбол-20, хөнгөн атлетик-12 тамирчин тус тус хичээллэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өсвөрийн шигшээ багийн төрлүүдээс сагсан бөмбөг, цана, хөл бөмбөг, буудлага, таеквондо, ширээний теннис, жүдо, самбо бөх, чөлөөт бөх, волейбол гэсэн спортын 9 холбоодын багш нартай гэрээ байгуулж ажиллаж байна.</li> <li>• Өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр спортын холбоодтой хамтран зохион байгуулж, нийт 1550 тамирчин хамрагдсан байна. Мөн орон нутгийн төсвийн 33.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цанын өсвөрийн шигшээ багийн бэлтгэл сургуулилтад цанын иж бүрдэл 10, тэшүүр 8 ширхэгийг худалдан авч тамирчдыг хэрэглэл материалаар хангах ажлыг зохион байгуулсан.</li> </ul>	
4.2	<p><b>Арга хэмжээ-2:</b> Аймгийн Засаг даргын 2015 оны А/445 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад жил бүр мөнгөн шагнал олгох</p>	Орон нутгийн төсөв 32.0 сая төгрөг	Дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдын тоо	-	2022 онд өндөр амжилт гаргасан 350 тамирчин, дасгалжуулагчийг 32.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулах.	Тайлант онд дэлхий, тив, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдын урамшууллыг 2022 төсвийн тодотголоор зориулалтыг өөрчилж биеийн тамир спортын жилийн үйл ажиллагаанд зарцуулахаар шийдвэрлэсэн. Тэмцээн уралдаанд оролцсон 240 тамирчинд орон нутгийн төсвөөс 107.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100%
	<p><b>Арга хэмжээ-3:</b></p>	Орон нутгийн	Зохион байгуулсан спортын төрлийн	2016 онд МБАТ-ний спортын XIV	Бүх ард түмний наадам	Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг	100%

4.3	Монголын бүх ард түмний спортын XV наадамд оролцох	төсөв 92.0 сая төгрөг	тоо, хамрагдсан тамирчдын тоо	их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 10 төрлөөр зохион байгуулж 480 тамирчин хамрагдсан. Шигшээ тэмцээнд спортын 14 төрлөөр 133 тамирчин оролцож нэгдсэн дүнгээр улсад 1-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн.	/спартакиад/-ын анхан шатны тэмцээнийг спортын 12 төрлөөр зохион байгуулж 550 тамирчныг хамруулна. Шигшээ тэмцээнд спортын 15 төрлөөр нийт 140 тамирчин оролцоно.	спортын 12 /сагсан бөмбөг 5х5, волейбол, даам, сагсан бөмбөг 3х3, шатар, ширээний теннис, дугуй, хонхот бөмбөг, суугаа волейбол, дифлимп сагсан бөмбөг, пара хөнгөн атлетик/ төрлөөр зохион байгуулж 1206 тамирчин, сонгон шалгаруулалт, сорилын 12 төрлөөр зохион байгуулж 124 тамирчид хамрагдаж нийт 1330 оролцогч хамрагдсан. Шигшээ тэмцээнд 21 төрлөөр 216 тамирчин өрсөлдөж, 21 аймгаас багийн дүнгээр Орхон аймаг дэд байр эзэлсэн.	
4.4	<b>Арга хэмжээ-4:</b> Монголын үндэсний спортын наадам VII наадамд оролцох		Зохион байгуулсан спортын төрлийн тоо, хамрагдсан тамирчдын тоо	2018 онд Үндэсний спортын VI их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 7 төрлөөр зохион байгуулж 407 тамирчин хамрагдсан. Шигшээ тэмцээнд спортын 11 төрлөөр 90 тамирчин	Анхан шатны тэмцээнийг спортын 7 төрлөөр зохион байгуулж 420 тамирчныг хамруулна. Шигшээ тэмцээнд спортын 15 төрлөөр нийт 140 тамирчин оролцоно.	Үндэсний спортын VII их наадмын анхан шатны тэмцээнийг орон нутагт өвлийн спортын 2 төрөл /мөсний шагай, мөсний сур/, зуны спортын 6 төрөл /үндэсний бөх, үндэсний сур, ширээний шагай, уран уургач бугуйлч, эмнэг булгиулагч, жороо морь, шаган харваа/ төрлөөр нийт 8 удаа зохион байгуулж зуны төрөлд 274 тамирчин, өвлийн төрөлд 120 тамирчин нийт 394 тамирчин оролцлоо. 2022 оны 08 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Хүй долоон худагт зохиогдсон шигшээ тэмцээнд 6 төрлөөр 96 тамирчин өрсөлдөж нийт 4 алт, 4 мөнгө, 1 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр 21	100%

				оролцож нэгдсэн дүнгээр улсад 1-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн.		аймгуудаас тэргүүн байр эзэлсэн амжилт үзүүлсэн.	
4.5	<b>Арга хэмжээ-5:</b> Монголын оюутны спортын V наадамд оролцох	-	Хамрагдсан баг, тамирчдын тоо	2017 онд Оюутны их наадмын сагсан бөмбөгийн анхан шатны тэмцээнийг зохион байгуулж 10 багийн 70 тамирчин оролцсон. Бүсийн тэмцээн, шигшээ тэмцээнд спортын 5 төрлөөр 65 тамирчин оролцсон.	Их дээд сургуулиудын баг тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулна.	Тайлан онд Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны А/17 тоот тушаалаар Монголын оюутны спортын V наадмын анхан шатны тэмцээн зохион байгуулагдаагүй. Тэмцээнд Орхон аймгаас суралцаж буй оюутнуудаас спортын 6 төрөлд 62 оюутан оролцоноос сагсан бөмбөгийн төрөлд 3 тамирчин алтан медаль, таеквондогийн 57кг-ын жинд мөнгө медаль, жүдо бөхийн төрөлд 81кг, 73 кг-ын жинд алтан медаль, 73 кг-ын жинд хүрэл медаль, чөлөөт бөхийн төрөлд 62кг-н жинд хүрэл медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.	100%
4.6	<b>Арга хэмжээ-6:</b> Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулах	Орон нутгийн төсөв 30.0 сая төгрөг	Зохион байгуулсан тэмцээний тоо	2021 онд зохион байгуулсан тэмцээний тоо 2	2022 онд 4 удаа улс, бүсийн чанартай томоохон тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулсан байна.	Тайлант онд улсын аварга шалгаруулах тэмцээн 5, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 4 тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 3-аар, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 3-аар тус тус нэмэгдүүлж зохион байгуулсан. Үүнд: -“Самбо бөхийн 2022 оны Монгол улсын өсвөр үеийн аварга” шалгаруулах тэмцээнд Улаанбаатар	100%

					<p>хот болон 16 аймгаас өсвөрийн үеийн 343 гаруй тамирчид;</p> <p>-Бадминтоны улсын аварга шалгаруулах тэмцээнийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Эрдэнэт спорт цогцолбор”-той хамтран зохион байгуулсан. Тус тэмцээнд 14 аймгийн 181 тамирчин А, В, С ангиллаар өрсөлдсөн;</p> <p>-“100 буудалт даам” сонирхогчдын улсын аварга шалгаруулах 5 дахь удаагийн тэмцээнийг зохион байгуулж, 8-80 насны 14 аймаг 9 дүүргийн 103 тамирчид;</p> <p>-“Уулын дугуйн улсын аварга шалгаруулах” тэмцээнд 27 байгууллагын 100 гаруй тамирчид;</p> <p>-Монгол Улсын Усанд сэлэлтийн 30 дахь удаагийн өсвөр, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 9 клубийн 130 тамирчид;</p> <p>-Монгол Улсын гавьяат тамирчин Д.Нармандахын нэрэмжит “Жудо бөхийн өсвөр үеийн аварга” шалгаруулах тэмцээнд 53 байгууллагын 1300 тамирчид;</p> <p>-“Жудо бөхийн өсвөр үеийн төвийн бүсийн аварга” шалгаруулах тэмцээнд 9 байгууллагын 490 тамирчид;</p> <p>-“Сумо бөхийн өсвөр үеийн төвийн бүсийн аймгуудын 9-12 насны аварга” шалгаруулах тэмцээнд 4 аймгийн 160 тамирчид;</p> <p>-Мөсний шагайн харвааны хойд бүсийн тэмцээний 2022 оны хаалтын харваа нээлттэй зохион байгуулагдаж Орхон, Дархан-Уул, Архангай</p>	
--	--	--	--	--	--	--



						аймгийн 20 багийн 40 гаруй харваач тус тус оролцсон. -“Самбо бөхийн 2022 оны Монгол улсын өсвөр үеийн аварга” шалгаруулах тэмцээн, сагсан бөмбөгийн Уурхайчин багт орон нутгийн төсвөөс 60.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.	
4.7	<b>Арга хэмжээ-7:</b> Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ангиллаар зохион байгуулж спортын төрлийн тоог нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 15.0 сая төгрөг	Зохион байгуулсан спортын төрөл, тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо	Спортын 15 төрлөөр 25 удаа тэмцээн зохион байгуулсан.	Спортын 18 төрлөөр 28 удаа тэмцээн зохион байгуулж 5200 тамирчин хамрагдсан байна.	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үеийн ангилалд спортын 20 төрлөөр 2964 тамирчин, залуучуудын ангилалд спортын 3 төрлөөр 211, насанд хүрэгчдийн дунд спортын 18 төрлөөр 2305, нийт 5480 тамирчин хамруулсан.	100%
4.8	<b>Арга хэмжээ-8:</b> Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, “Өвлийн спортыг хөгжүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв 45.0 сая төгрөг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Өвлийн спортоор хичээллэгч 1400 хүн аймгийн АШТ-ийг спортын 3 төрлөөр зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилт 46,8%	Хичээллэгчдийн тоог 2022 онд-1680 хүнд хүргэх, аймгийн АШТ-ийг спортын 4 төрлөөр зохион байгуулж, 65%-д хүргэнэ.	Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 4 үндсэн зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2022 онд 11 арга хэмжээг 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувиар, 1 арга хэмжээг 50 хувиар, 2 арга хэмжээг 30 хувиар тус тус хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг 86.5 хувьд хүргэж ажилласан. Өвлийн спортын секц, дугуйланд хоккейн спортоор 90, гүйлтийн цана, дугуйд цана 45, уулын цана 100, сноуборд-30, мөсөн шагай 63, мөсөн сур 43, нийт 6 төрлөөр 370 гаруй тамирчин хичээллэж байна. Өмнөх оноос мөсөн сур, уулын цана, сноуборд спортын төрөл, тамирчдын тоо сүүлийн 2 жилд 180-аар нэмэгдүүлсэн. Франц улсын Засгийн газрын өвлийн спортын үндэсний төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Санамж бичигт Франц улсаас 6	100%

						<p>тамирчин дасгалжуулагч Орхон аймагт бэлтгэл хийх, Орхон аймгаас 6 тамирчин дасгалжуулагч Франц улсад бэлтгэл хийх, цанын хэрэглэл материалын туслалцаа авах, нөхөрсөг тэмцээн уралдаан зохион байгуулах ажлыг 2023 оны 2 дугаар улирлаас эхлэн зохион байгуулахаар тусгасан. Мөн Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын дагуу Монголын бүх ард түмний XVI дугаар наадам, Монголын Хүүхдийн спортын VII дугаар наадмын өвлийн төрлийн тэмцээнүүдийг өвлийн спортын барилга байгууламждаа түшиглэн зохион байгуулах саналыг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж, сонгон шалгаруулалтад өрсөлдсөн.</p> <p>Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны А/196 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг Орхон аймагт ирж ажиллан, тус хорооны даргын 2022 оны А/203 дугаар тушаалаар Монголын Бүх ард түмний спортын XVI дугаар наадам, Монголын Хүүхдийн спортын VII дугаар наадмын өвлийн төрлүүдийн тэмцээнийг 2023 онд Орхон аймагт зохион байгуулах эрх олгосон.</p>	
4.9	<p><b>Арга хэмжээ-9:</b> “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн” болон ерөнхий боловсролын сургуулийн гадна талбайд өвлийн</p>	Орон нутгийн төсөв	Мөсөн гулсуурын талбайн тоо	Аймгийн хэмжээнд цанын бааз 1, мөсөн	Спорт амралтын хүрээлэнгийн урд уулын энгэрт цанын зам, ерөнхий	Тайлант онд 6 байршилд мөсөн талбай, 1 байршилд цана, чарганы цасны зам зам тавьж цана, чарга, тэшүүр, хоккейн спортоор 3200 гаруй иргэн хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.Үүнд:	85.7%

	спортоор хичээллэх орчин бүрдүүлэх	6.0 сая төгрөг		гулгуурын гадна талбай 3 байна.	боловсролын 6 сургуулийн спортын гадна талбайд жил бүр мөсөн гулсуурын талбайг тохижуулж хийсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>• “Эрдэнэт спорт, амралтын хүрээлэн”-гийн 400м мөсөн талбай;</li> <li>• Сархиа цанын баазын цанын зам, талбай;</li> <li>• Хангарьд спорт цогцолборын дэргэдэх хоккейн талбайд тус тус мөс цасны зам;</li> <li>• Гэр хорооллын байршилд ерөнхий боловсролын 2, 17, 20 дугаар сургуулиудын гадна талбайд мөс тавьж, сурагчид, тамирчид сонирхогчдыг цана, тэшүүр, хоккейн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.</li> </ul>	
	Стратеги төлөвлөгөөний зорилт-5: Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэр, Засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргын үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллана.	Улсын төсөв-323.0 сая төгрөг, Орон нутгийн төсөв 2.0 сая төгрөг	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үүрэг даалгаврыг биелүүлсэн байна.	Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, журмыг хэрэгжүүлэн ажилласан.	Төрийн байгууллагад мөрдөгдөх хууль, салбарын хууль тогтоомж Засгийн газар аймгийн ИТХ, Засаг даргын бодлого шийдвэр үүрэг даалгавар хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна.	Тус байгууллагад мөрдөгдөх хууль, салбарын хууль тогтоомж Засгийн газар аймгийн ИТХ, Засаг даргын бодлого шийдвэр үүрэг даалгавар хугацаандаа хэрэгжиж байна.	100%
5.1	<b>Арга хэмжээ-1:</b> Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт	-	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Биелэлт-85%	Биелэлт-90%	Тус газар нь биеийн тамир, спортын тухай хуулийн 8 заалт, Ерөнхийлөгчийн зарлиг 2, Засгийн газрын тогтоол 3, Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоол 5 тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%

	шинжилгээ үнэлгээний хэлтэс, Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороонд хугацаанд нь тайлагнана.						
5.2	<b>Арга хэмжээ-2:</b> Авлигаас ангид байж төрийн жинхэнэ албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг гарган Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлж, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийн хувь	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 3 албан хаагч буюу 100 хувь	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 5 албан хаагч буюу 100 хувь хүргүүлсэн байна.	Авлига, ашиг сонирхлын зөрчил, хүнд сурталгүй ажиллаж, Төрийн захиргааны 3 албан хаагч 2021 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаж мэдүүлсэн. Биеийн тамир спортын улсын хорооноос 21 аймгийн биеийн тамир спортын газрын бүтэц орон тоог шинэчлэх чиглэлийн дагуу шинээр батлагдах төрийн захиргааны 5 албан хаагч нэмэгдэхээр тооцоолж зорилтот түвшинг гаргасан боловч нэмэгдээгүй.	100%
5.3	<b>Арга хэмжээ-3:</b> Бүх ажилчдыг монгол бичгийн сургалтын хөтөлбөрт хамруулах, анхан шатны сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулах	-	Мэдлэгээ дээшлүүлсэн албан хаагчдын хувь	-	Албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулна.	Байгууллагын албан хаагчийн сургалтын 2022-2024 оны хөтөлбөр, 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Монгол үндэсний бичиг”-ийн анхан шатны 6 удаагийн сургалтад албан хэрэг хөтөлдөг 14 ажилтан албан хаагчийг хамруулж, үндэсний бичгээр унших бичих чадварыг сайжруулсан.	100%
5.4	<b>Арга хэмжээ-4:</b> Ажилтан, албан хаагчдыг хуульд заасан үндэслэлээс бусад тохиолдолд төрийн албанаас халахгүй байх;	-	Хамтын гэрээний хэрэгжилтийн хувь	Хууль тогтоомжийн хэрэгжилт	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.	2022 онд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд хөдөлмөрийн харилцаатай холбогдсон ажлаас хууль бусаар халагдсан зөрчил, маргаан гараагүй ажилласан байна. Ажлаас чөлөөлөгдсөн 5 албан хаагч байна. Үүнээс: өөрийн хүсэлтээр – 4 албан; өндөр настны тэтгэвэрт -1 албан хаагч. Хамтын гэрээний хэрэгжилт 100% гэж дүгнэсэн.	100%

5.5	<b>Арга хэмжээ-5:</b> Ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажиллана.	-	Нэмэгдсэн ногоон байгууламжийн тоо	Байгууллагын н хашаан дотор 108 мод хайс арчлан ургуулж байна.	Байгууллагын төмөр хашааг мод бутаар сольж, хуваарилсан байршилд Спортын ногоон төгөл байгуулна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангаж 2022 оны 5 дугаар сарын 14-ний өдөр “Сархиа” ууланд төрийн байгууллагуудад хуваарилсан газарт тус газрын 16 ажилтан 20 ширхэг шинэс мод, намрын мод тарих өдөр буюу 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 20 ажилтан 35, нийт 55 шинэс мод тарьж ногоон төгөл байгуулсан.	100%
5.6	<b>Арга хэмжээ-6:</b> Хог хаягдлын менежментийг сайжруулж ажиллана.	-	Ялган тэмдэглэгээ хийгдсэн хогийн савны тоо	-	Байршлыг зөв сонгож ялган ангилсан хогийн сав, таних тэмдгийг хийсэн байна.	Тус газрын эзэмшил Уурхайчин заал болон “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн” дэх хогийн төмөр сараалжин савыг засаж ангилан, хаях таних тэмдгийг байршуулж, шинээр 1 хогийн сав хийсэн. Хог хаягдлыг аймгийн Хот тохижуулах газартай гэрээний дагуу сард 1 удаа ачилт хийлгэн, нийт 11 удаа ачилт хийлгэсэн. Тус байгууллагын ажилтан албан хаагчид А заал, Уурхайчин заал, “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-гийн ойр орчмыг тогтмол цэвэрлэж байна.	100%
5.7	<b>Арга хэмжээ-7:</b> Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороонд тайлагнана.	-	Тайланг хугацаанд нь хүргүүлсэн тоо	Ил тод байдлын тайланг 3 удаа хүргүүлсэн	Дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн байна.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн 2022 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн гаргаж аймгийн ЗДТГ болон Биеийн тамирын спортын улсын хороонд хугацаанд нь хүргүүлсэн.	100%

5.8	<p><b>Арга хэмжээ-8:</b> Байгууллагын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн арга хэмжээг зохион байгуулах</p>	Орон нутгийн төсөв 2.0	Хамрагдсан иргэдийн тоо	<p>Өмнөх онд спортын холбоо, фитнес клубтэй хамтран зохион байгуулж 850 иргэн хамрагдсан.</p>	<p>Спортын холбоо, фитнес клубтэй хамтран зохион байгуулж 900 иргэн хамруулсан байна.</p>	<p>Тайлант онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 3 чиглэлээр зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Биеийн тамир, спортын бодлого үйл ажиллагааг сурталчлах зорилгоор аймгийн хэмжээнд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа 15 спортын холбоодын тэргүүн, нарийн бичиг нартай уулзалт хэлэлцүүлгийг хийж 6 төрлийн асуудлыг танилцуулж цаашид хамтран ажиллахад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх гарц шийдлийн талаар ярилцлаа. Мөн “Тамирчдын баярын өдөр”-ийг спорт холбоодтой хамтран зохион байгуулж төрийн байгууллагууд болон иргэдийн дунд буудлага, хүндийн өргөлт, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, 120 гаруй иргэдийг хамруулсан.</li> <li>2. “Илүүдэл жингүй –Эртэч Монголчууд” арга хэмжээг 10 албан хаагч 72 ажлын өдөр зохион байгуулж, нээлт, хаалтын арга хэмжээнд 600 гаруй иргэдийг хамруулсан.</li> <li>3. Аймгийн төрийн болон төсөвт байгууллага 35, төрийн бус байгууллага 29, 12 томоохон аж ахуйн нэгж байгууллагатай хамтран биеийн тамир спортын 16 удаагийн өдөрлөг, тэмцээн, уралдаан зохион байгуулж 6347 ажилтан албан хаагчдыг</li> </ol>	100%
-----	---	------------------------	-------------------------	---	---	---	------

						хамруулж, байгууллагын үйл ажиллагаа сурталчлан ажиллалаа. Мөн аймгийн ИТХ-аас зохион байгуулсан “Иргэдийн оролцоо-Төлөөлөгчдийн манлайлал-Төрийн үйлчилгээ” сэдэвт нэгдсэн өдөрлөгт байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажилласан.	
5.9	<b>Арга хэмжээ-9:</b> Ажлын байранд цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах замаар халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж “Ковид-19” халдвараас урьдчилан сэргийлж, дархлаажуулалтад хамрагдана.	Байгууллагын төсөв 3.1 сая төгрөг	Халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтийн хувь	-	100% биелүүлнэ.	Тус газрын даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар “Коронавируст халдвар”-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах түр журам”-ыг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Түр журмаар ажлын байранд ажилтан албан хаагчдыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрх, үүргийг журамлаж, А, Б заал, албан өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээнд жавелин, гар ариутгагч санитол зэрэг шаардлагатай цэвэрлэгээний материалаар ханган ажиллаж 3.1 сая төгрөгийг зарцуулсан. Мөн ариутгал халдваргүйжүүлэлтийн “Сайн түшиг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, улирал тутамд А, Б зааланд хор цацуулж хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийлгэн ажиллаж байна.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилт-6. Төсвийн шууд захирагч хууль тогтоомжийн дагуу төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах		Улсын төсөв – 323.0 сая төгрөг	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өргүй ажилласан байна.	2021 онд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг 21 сая төгрөгөөр буюу 65 хувиар	Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж, төсвийг хэмнэж ажиллана.	Тус газрын дарга нь хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор бодлого, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 126, хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 63 тус тус баталж, Биений тамир спортын улсын хорооноос 378.5 сая, орон нутгийн төсвөөс 340.1 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн	98%

			хэмнэж өр, өглөг, авлагагүй ажилласан.		тухай хуулийн дагуу зарцуулан, орон нутгийн төсөвт 15.0 сая төгрөгийн орлогыг 100% төвлөрүүлэн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган батлагдсан төсвөөс 5.6 сая төгрөгийн хэмнэлт гарган ажиллалаа.		
6.1	<b>Арга хэмжээ-1:</b> Санхүүжүүлсэн төсвийн хүрээнд өр, авлага үүсгэхгүй батлагдсан төсөвтөө багтаан ажиллах, үр ашиггүй зардлыг багасган ажиллана.	-	Байгууллагын төсвийн зарцуулалт ба үр ашиггүй зардлыг багасгасан хувь	Байгууллагын төсвийн зарцуулалт 100 хувь	Байгууллагын төсвийн зарцуулалтыг 100% төсөвтөө багтаан зарцуулсан байна.	Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир спортын улсын хорооноос 11 дүгээр сарын 28-ны байдлаар 378.5 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласнаас цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлд 242.0 сая, биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд 38.3 сая, нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээний зардалд 22.3 сая, бусад тогтмол зардалд 24.9 сая төгрөгийг зарцуулан ажиллалаа. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хуулийн хугацаанд нь гаргаж, Биеийн тамир спортын улсын хороо болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж байна. Татвар, нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд шивж, илгээн өр авлагагүй ажиллаж байна.	100%
6.2	<b>Арга хэмжээ-2:</b> Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган хууль журмын дагуу холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангана.	-	Шилэн дансны мэдээллийг оруулсан хувь	Шилэн дансны мэдээллийн 90 хувь	/Санхүү төрийн сангийн хэлтэст/ 100 хувь оруулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн дагуу 11 дүгээр сарын 28-ны байдлаар 122 мэдээлэл байршуулахаас 117 мэдээлэл хугацаанд нь байршуулж 5 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байна.	95.9%
<b>Стратеги төлөвлөгөөний зорилт-7.</b>			Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Хамтран ажиллах гэрээний	Орхон, Булган аймгийн Биеийн тамир,	Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хүрээнд спортын чиглэлээр 4	100%



<p>Орхон, Булган аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>Орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөг</p>		<p>хүрээнд 2 аймгийн спортын газрын хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлт 100% дүгнэгдсэн.</p>	<p>спортын газрын дарга нар хамтран ажиллах ажлын гэрээ байгуулан жил бүр ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	<p>зорилтын хүрээнд 11 удаа тэмцээн уралдаан, 3 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж, Булган аймагт зохион байгуулагдсан боксын улсын аварга шалгаруулах тэмцээнд хэрэглэл материалаар, бүх ард түмний наадмын сагсан бөмбөгийн тэмцээнд 4 шүүгчийг оролцуулж дэмжлэг үзүүлж ажилласан. -Хангайн бүсийн спортын байгууллага /Архангай, Булган, Баянхонгор, Хөвсгөл, Орхон/-н дунд спортын 4 төрөл /сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, буудлага/-т нөхөрсөг тэмцээн, уулзалтыг аймагтаа зохион байгуулж, 5 аймгийн 60 гаруй албан хаагчдыг хамруулсан.</p>	
<p><b>Стратеги төлөвлөгөөний зорилт-8.</b> Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, байгууллагын дотоод хяналт шалгалтын комиссын үйл ажиллагааг сайжруулах;</p>	<p>Байгууллагын төсвөөс 4.5 сая төгрөг</p>	<p>Төлөвлөгөөний хувь</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 онд 85 хувиар биелүүлж ажилласан.</p>	<p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 90 хувьд хүргэж ажиллана</p>	<p>2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж, Биеийн тамир спортын улсын хорооны дарга болон аймгийн Засаг даргаар батлуулан ажиллалаа. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 48 удаагийн шуурхай хуралд биечлэн оролцож, хурлаас өгөгдсөн 10 удаагийн үүрэг даалгаврыг биелүүлж, байгууллагын шуурхай хурлыг 26 удаа зохион байгуулж, 115 удаа үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажилласан. Мөн үйл ажиллагааны чиглэлээр А тушаал 126, хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 63 тус тус баталж, сар бүр үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, дотоод хяналт шалгалтыг 6 удаа зохион байгуулж ажиллалаа.</p>	<p>97.1%</p>

8.1.	<b>Арга хэмжээ-1:</b> Биеийн тамир, спортын газрын бүтэц орон тоог шинэчлэн батлуулж, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Захирамжийн хэрэгжилтийн хувь	2021 онд төрийн захиргааны 3, төрийн үйлчилгээний 28 албан хаагчтай ажилласан.	Төрийн захиргааны албан хаагчийг нэмэгдүүлж ажиллана.	Биеийн тамир, спортын улсын хорооноос чиглэл өгч, Засгийн газраас тогтоол гараагүй тул хэрэгжээгүй.	Үнэлэх боломжгүй
8.2	<b>Арга хэмжээ-2:</b> Байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийх замаар төрийн захиргааны албан тушаалтны “Албан тушаалын тодорхойлолт”-ыг шинэчлэн Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл авах	-	Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын тоо	Батлагдсан албан тушаалын тодорхойлолт 3	Бүтэц орон тооны өөрчлөлттэй холбогдуулан 8 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинээр батлуулна.	Биеийн тамир, спортын улсын хорооноос ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын бүтэц, орон тооны шинэчлэлттэй холбогдуулан төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/22 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан.	70%
8.3	<b>Арга хэмжээ-3:</b> Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Байгууллагын төсөв 300.0 мянга	Хөтөлбөрийн биелэлтийн хувь	Төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад хамруулсан.	Шинээр баталсан хөтөлбөрийн биелэлтийг 30 хувиар хэрэгжүүлнэ.	Тус газрын даргын 2022 оны “Хөтөлбөр батлах тухай” А/78 дугаар тушаалаар албан хаагчдын сургалтын 2022-2025 оны хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг 100 хувиар хэрэгжүүлэн ажилласан. Төлөвлөгөөний хүрээнд: -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” арга зүйн 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор давхардсан тоогоор 50 албан хаагч; -Байгууллагын 5 удаагийн дотоод сургалтад давхардсан тоогоор 54 албан хаагч;	100%

						<p>-Мэргэжил дээшлүүлэх 5 удаагийн сургалтад 6 албан хаагч;          -Монгол үндэсний бичгийн анхан шатны сургалтад 14 албан хаагч;          -Аймгаас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад 8 албан хаагч;          -Орой, эчнээ ангид бакалаврын боловсрол эзэмшихээр 4, магистрын сургалтад 2 албан хаагч тус тус суралцаж байна.</p>	
8.4	<p><b>Арга хэмжээ-4:</b>          Төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>Байгууллагын төсөв          1.5 сая</p>	<p>Төлөвлөгөөний биелэлтийн хувь</p>	<p>Албан хаагчдад дэмжлэг тусламж үзүүлсэн.</p>	<p>Шинээр баталсан хөтөлбөрийн биелэлтийг 25 хувиар хэрэгжүүлнэ.</p>	<p>Тус газрын даргын 2022 оны “Хөтөлбөр батлах тухай” А/77 дугаар тушаалаар албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022-2025 оны хөтөлбөрийг шинэчлэн баталсан.          Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг 100 хувиар хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд:          -2022 оны ээлжийн амралтыг даргын 2022.03.21-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар батлуулж, хуваарийн дагуу нийт 25 албан хаагчдад олгосон.          -7 хоногийн амралтын өдөр уралдаан, тэмцээн дээр ажиллаж албан хаагчдын илүү цагийн хөлсийг тушаалаар болон ажиллуулж байгаа байгууллагаас гаргуулан өгч байна.          -Ар гэрийн гачигдалтай 1 ажилтанд 150.0 мянган төгрөг, өндөр үнэтэй шинжилгээ хийлгэх шаардлагатай 1 ажилтанд 500.0 мянган төгрөг, өндөр настны тэтгэвэр гарсан 1 ажилтанд 15.794.0 мянган төгрөгийн, түлээ, нүүрс авахад зориулж 4 ажилтанд тус бүр 180.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.          -Ажилтан албан хаагчдын орон сууцны нөхцөл байдалд судалгаа</p>	100%

						<p>хийж ажилчдын орон сууц бариулах газрын асуудлыг шийдвэрлүүлэх талаар хүсэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.</p> <p>-Ар гэрийн гачигдал, сургалтад хамрагдах, хувийн чөлөө авах хүсэлт гаргасан нийт 6 ажилтанд даргын тушаалаар цалинтай, цалингүй чөлөө олголоо.</p> <p>- 2 компьютер, 1 ширээг ажилтан албан хаагчдад олгосон.</p> <p>-Ажилтан албан хаагчдын нийт 30 хүүхдэд 880.0 мянган төгрөгийн хүүхдийн баярын бэлэг гардуулан өгсөн.</p> <p>-Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон.</p>	
8.5	<p><b>Арга хэмжээ-5:</b> Орон тооны бус салбар, зөвлөл, комисс, багийн дүрэм журмыг шинэчлэн үйл ажиллагааг сайжруулах</p>	-	Шинэчлэгдсэн дүрэм журмын тоо	Орон тооны бус зөвлөл хууль журмын дагуу ажилласан.	Орон тооны бус зөвлөл, комиссын үйл ажиллагаа сайжирсан байх	<p>Тайлант онд 11 орон тооны бус зөвлөл, комисс ажиллаж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгууллагын ёс зүйн зөвлөлийн 1 гишүүн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийт ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулсан.</li> <li>• Өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллого, үзлэгийг зохион байгуулж ажилласан.</li> </ul>	100%

					<ul style="list-style-type: none"><li>• Дотоод хяналт шалгалтын комиссыг даргын 2022 оны А/14 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, дотоод хяналт шалгалтыг 6 удаа зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан.</li><li>• Байгууллагын “Даргын дэргэдэх зөвлөл”-ийг даргын 2022 оны А/28 дугаар шинэчлэн байгуулж, алба нэгжийн ахлах мэргэжилтнүүдийн 7 хоногт хийсэн ажлын талаарх мэдээллийг хэлэлцүүлж, шийдвэрийг тухай бүр нь гаргаж ажлын үр дүнг сайжруулан ажилласан.</li><li>• Эцэг эхийн зөвлөл нь тайлант оны эхний улиралд ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажилтан албан хаагчдад зөвлөмж зөвлөгөө өгч, аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Бүх хайраа гэр бүлдээ” аяны хүрээнд “Аав, ээж, би” тэмцээн зохион явуулж ажиллалаа.</li><li>• Ахмадын зөвлөл нь байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан 10 ахмад ажилтныг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулжээ.</li><li>• Гамшгаас хамгаалах орон тооны бус алба нь байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийлгэж, шинэчлэн батлуулж ажилласан.</li><li>• Баримт бичиг нягтлан шалгах комисс, дотоод хяналт шалгалтын</li></ul>
--	--	--	--	--	---

						комисс, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан нар нь жилийн ажлын төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан ажиллалаа.	
8.6	<b>Арга хэмжээ-6:</b> Дотоод хяналт шалгалтыг улирал бүр зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах	-	Зохион байгуулсан шалгалтын тоо	1 удаа хяналт хийгдсэн.	2022 онд 4-өөс доошгүй удаа хяналт хийнэ.	Тус газрын даргын 2022 оны “Дотоод хяналт шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” А/14, “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам батлах тухай” А/16 дугаар тушаалыг тус тус баталж, жилийн ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын төсвийн зарцуулалт, спорт холбоодод олгосон санхүүжилт, орлогын төлөвлөгөөний биелэлт, байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт ашиглалт, хүний нөөцийн чиглэлээр, спорт заалны цэвэрлэгээ үйлчилгээний чиглэлээр 6 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох ажилтан албан хаагчдад зөвлөмж өгч ажилласан.	100%
8.7	<b>Арга хэмжээ-7:</b> Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх	-	Ажлын үр дүнг дүгнэсэн тоо	4 удаа дүгнэсэн.	2022 онд 4 удаа дүгнэнэ.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг стратегийн төлөвлөгөө болон салбарын хууль тогтоомж бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж тайлант оны 3 дугаар сард аймгийн Засаг дарга, Биеийн тамир спортын улсын хорооны даргаар батлуулан эхний хагас жилийн биелэлтийг гарган хугацаанд нь тайлагнасан. Ажилтан албан хаагчдад ажлын үр чадварын нэмэгдлийг 6 удаа, албан хаагчдын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж байгууллагын даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн Б/29	100%

						дүгээр тушаалаар мөнгөн урамшууллыг 7 дугаар сард олгосон.	
8.8	<p><b>Арга хэмжээ-8:</b> Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг сайжруулах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний биелэлт 95%	Төлөвлөгөөний биелэлтийг 100% хүргэнэ.	<p>Байгууллагын ажилтан албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор жилийн ажлын төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөний хүрээнд: -“Ковид-19” халдвараас урьдчилан сэргийлэх түр журмыг даргын 2022 оны А/06 дугаар тушаалаар баталж хэрэгжүүлэн ажилласан. -Цагаан сарын болон үндэсний баяр наадмын өдрүүдэд “Хариуцлагатай жижүүр ажиллуулах хуваарь”-ийг даргын 2022 оны А/08, А/94 дүгээр тушаалаар баталж зөрчилгүй ажилласан. -Дотоод хяналт шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг даргын 2022 оны А/16 дугаар шинэчлэн байгуулсан. -Хөдөлмөрийн дотоод журмыг хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэн хамт олны хурлаар хэлэлцэн даргын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан. -Даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг даргын 2022 оны А/28 дугаар тушаалаар шинэчилсэн. -Шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар ажилтан албан хаагчдад 2 удаа мэдээлэл өгсөн. -Аймгийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний хүрээнд А, Б заалны дулаан, цэвэр, бохир усны шугам, узелийг дулаалж, засвар үйлчилгээг хийж ажилласан. Байгууллагын шуурхай хурлыг 26 удаа зохион байгуулж, 115 удаа үүрэг даалгавар өгч, тайлант онд өөрийн</p>	90%

						эзэмшлийн барилга байгууламж бусад үйл ажиллагаанд гэмт хэрэг, зөрчилгүй ажиллалаа.	
8.9	<b>Арга хэмжээ-9:</b> Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандартын талаар сургалт зохион байгуулах	Байгууллагын төсөв 200.0 мянган төгрөг	Зохион байгуулсан сургалтын тоо	2 ажилтан сургалтад хамрагдсан.	Албан хаагчдад үе шаттай сургалт зохион байгуулсан байна.	Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Чанарын удирдлагын тогтолцоо" сэдэвт сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан. Байгууллагын хэмжээнд "ISO 9001 стандартын талаарх ойлголт" сургалтад 30 албан хаагчийг хамруулсан.	100%
8.10	<b>Арга хэмжээ-10:</b> Амралт чөлөөт цагийн өрөөг тохижуулах	Байгууллагын төсөв 500.0 мянган төгрөг	Тохижилтын хувь	-	Тохижилтыг сайжруулсан байна.	Тус газрын даргын 2022 оны А/101 дүгээр тушаалаар 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд А заалны хана, амралтын болон жижүүрийн өрөөг, Б заалны жижүүрийн болон бэлтгэлийн өрөө тасалгаанд дулаалга, замаск будгийн ажил хийж, өнгө үзэмжийг сайжруулан иргэд тамирчид болон ажилтан албан хаагчдад ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа. Засвар үйлчилгээнд орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр А, Б заалны орлогоос 6.0 сая төгрөгийг зарцуулсан.	100%
8.11	<b>Арга хэмжээ-11:</b> Албан хаагчдын ажил үүргийн онцлогт тохирсон хувцсаар жигдрэх	Байгууллагын төсөв 2.0 сая төгрөг	Хувцас жигдрэлтийн хувь	-	100% хангагдана	Нийт 30 ажилтан албан хаагчтай бөгөөд дарга 1, ахлах мэргэжилтэн 2, мэргэжилтэн 7, үйлчилгээний 4 ажилтан, үйлчлэгч, жижүүр, харуул 16 ажилтан бэлтгэлийн өмд цамцаар жигдэрсэн.	100%
8.12	<b>Арга хэмжээ-12:</b> Ажлын байранд "Идэвхтэй хөдөлгөөн Эрүүл мэнд" хөдөлгөөн өрнүүлж хэвшил болгох	-	Дасгал хөдөлгөөн зохион байгуулсан тоо	-	Дасгал хөдөлгөөнийг хэвшүүлсэн байна.	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар 02 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдөр хүртэл зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяны арга хэмжээг ажлын байранд буюу А зааланд өглөө бүр 06.30-07.30 цагт 10 албан хаагч ажлын 72 өдөр зохион	100%



						байгуулж, дасгал хөдөлгөөнийг өөрсдөө хийж иргэдийг манлайлан ажилласан. Мөн ажилтан албан хаагчдын хөдөлгөөний хомсдолыг арилгах зорилгоор 7 хоног бүр 2 цагийг нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннисний чөлөөт тоглолтыг 27 удаа, хангайн бүсийн спортын байгууллагуудын дунд зохиогдсон спортын 4 төрөл /сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, буудлага/-т нөхөрсөг тэмцээнийг тус тус зохион байгуулсан.	
8.13	<b>Арга хэмжээ-13:</b> Байгууллагын мэдээллийн веб сайтыг хөгжүүлж, мэдээ мэдээллийн тоог нэмэгдүүлж ил тод байдлыг хангана.	-	Мэдээллийн тоо	56 удаа мэдээ мэдээлэл оруулсан	Мэдээ мэдээллийг тухай бүр оруулсан байна.	Тус байгууллагын Orkhon@sport.gov.mn веб сайтад тэмцээн уралдаантай холбогдолтой зурган мэдээлэл 40, бусад веб хөгжүүлэлтэй холбоотой 16 мэдээлэл болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, байгууллагын даргын тушаал зэрэг нийт 120 мэдээллийг байршуулсан. Мөн иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа спортын болон нийтийг хамарсан арга хэмжээний мэдээллийг тогтмол оруулан ажиллаж байна.	100%
8.14	<b>Арга хэмжээ-14:</b> Сошиал сүлжээнд мэдээ мэдээлэл сурталчилгааны тоог нэмэгдүүлэх	-	Мэдээллийн тоо	60 удаа мэдээ мэдээллийг түгээсэн.	150 удаа мэдээ мэдээллийг оруулсан байна.	Тус газрын “Биеийн тамир, спортын газар” пэйж хуудсанд биеийн тамирын өдөрлөг, спортын мэдээ, мэдээлэл, статистик мэдээ, шилэн данс, ил тод байдал, хууль дүрэм, Монголын бүх ард түмний спортын XV наадам, Үндэсний спортын VII наадмын тэмцээний мэдээ мэдээлэл, наадмын цахим бүртгэл зэрэг 162 мэдээллийг	100%

						нэгтгэн оруулж давхардсан тоогоор 132856 иргэний хандалт авсан байна.	
8.15	<b>Арга хэмжээ-15:</b> И-оффис программын ашиглалтыг нэмэгдүүлэх	-	И-оффис программын ашиглалтын хувь	И-оффис ашиглалт 85%	И-оффис хэрэглээг 90%-д хүргэж ажиллана.	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд и-оффисс программыг ашиглаж байна. Байгууллагад ирсэн, явуулсан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг 7 хоногт 1 удаа тогтмол гаргаж, даргаар хянуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн и-оффисс программ хэрэглэгч 13 албан хаагч баримт бичиг төлөвлөх, шийдвэрлэх, төлөвлөх, тайлагнах үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэж хэвшсэн.	100%
<b>Дундаж үнэлгээ</b>							<b>97.4%</b>